

“Хай Би Ойл” ХК-ийн 2020 оны жилийн

үйл ажиллагааны тайлан

Нэр: “Хай Би Ойл” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110 тоот

Утас: (+976) – 8811 9740, 9990 4034

Улсын бүртгэлийн дугаар: 9010001063

Регистрын дугаар: 2615134

Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх,  
дахин боловсруулах тусгай зөвшөөрлийн бүртгэлийн дугаар: 000009

Үйл ажиллагааны чиглэл: Техникийн хаягдал тос дахин боловсруулах

Үнэт цаасны тоо ширхэг: 52,118,954 ширхэг

**Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд: Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:**

2019 оны түүхий эдийн тосны үлдэгдэл нөөц 251,127 литр, боловсруулсан тосны нөөц /Мазут/ 105,222 литр байсан ба 2020 он гарснаас хойш тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК нь нийт 861,710 л түүхий эдийг байгууллага болон хувь хүнээс цуглуулсан байна. Үүнээс 613,972л мазут боловсруулан авч 3 аж ахуйн нэгжид 458,579,414₮ /НӨАТ орсон үнэ/ төгрөгийн үнэ бүхий 582,934л мазутыг борлуулсан байна. Дээрх тоон үзүүлэлтүүдийн задаргааг харуулбал:

Түүхий эд материал:

Нэр	Нэгж	2019 оны үлдэгдэл	2020 оны хагас жилд
Түүхий эд буюу ажилласан масло	литр	251,127	861,710
<b>Нийт</b>	литр	<b>1,112,837</b>	

Борлуулалт:

№	Худалдан авсан байгууллагын нэр	Хэмжээ	НӨАТ орсон үнэ /төгрөг/	
			Нэгж үнэ	Нийт үнэ
1	Монгол Битум Индустрал ХХК	198,570 л	850	168’784’614
2	“Наранбулаг Хан” ХХК	204,473 л	900/700	163’871’100
3	Дэвжих Эрдэнэ ХХК	179,891 л	700	125,923,700
<b>Бүгд дүн</b>		<b>582,934 л</b>		<b>458,579,414</b>

**Гэрээ хэлиэлүүд болон томоохон худалдан авагчид:**

2020 оны тайлант хугацаанд түрээсийн болон санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой 2 гэрээ, ажил үйлчилгээ үзүүлэх 9 гэрээ, худалдах ба худалдан авахтай

холбогдолтой 5 гэрээнүүдийг тус бүр байгуулсан байна.2019 онд хийгдсэн “Таван Богд”ХХК, “М-Ойл Любрикэнтс”ХХК, “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК, “Си Ар Найнтээн Бюро Монголиа” ХХК зэрэг ажилласан масло худалдан авах гэрээнүүд хугацаа нь дуусаагүй тул үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна.

**2020 онд хийгдсэн гэрээнүүдийг жагсаавал:**

№	Гэрээ байгуулсан компани	Гэрээний агуулга	Эхлэх	Дуусах	Гэрээний үнэ
Түрээс, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой					
1	“ҮЦТХТ” ХХК	Үнэт цаасны хадгаламжийн төлбөр гүйцэтгэх гэрээ	2020/01/01	2020/12/31	400,000₮
2	“Аудит” ХХК	Хөрөнгийн үнэлгээ хийх	2020/10/04	2020/04/20	10,000,000₮
3					
Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ					
1	“Би И Би партнерс” ХХН	Хууль зүйн байнгын үйлчилгээ үзүүлэх	2020/04/01	2020/10/01	1,000,000₮
2	СХД-ийн Татвар,Тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээний төв	ХХҮХураамж, тээвэрлэх гэрээ	2020/01/01	2020/12/31	Улирал бүр 60’000₮
3	“Үнэмлэхүй эрх” ХХН	Хууль зүйн туслалцаа үзүүлэх	2020/01/15	2020/04/01	5,150,000₮
4	УБТЗ ХНН ЭХУХ 1 анги	Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ	2020/03/14	2023/03/14	Сар бүрийн хэрэглээний үнэ
5	“Цагаан уулын оргил” ХХК	Байгаль Орчны зөвлөх үйлчилгээний гэрээ	2020/03/05	2020/03/26	3,000’000₮
6	“Сөүл Сэниорс Товер” ХХК	Ажилчдын эрүүл мэндийн багц шинжилгээний гэрээ	2020/04/06	2020/11/30	2,700,000₮
7	“Хэлт энд сэфти солушинс” ХХК	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх гэрээ	2020/09/22	2020/10/01	1,124,530₮
8	Би Си Ти ХХК	Камер суурилуулалтын гэрээ	2020/10/21	2020/10/28	6,541,000₮
	СХД-н 20 хороо,цагдаа, компани	Гурвалсан гэрээ	2020/11/14	2021/11/14	

9	Сансар дижитал ХХК	Олон сувгийн тоон телевизийн хэрэглэгчийн үйлчилгээний гэрээ	2020/07/23		70,000₮
10	Иргэн Р.Оюунбат	Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах гэрээ	2020/02/14	2020/04/15	20,000,000₮
11	Иргэн Б.Бямбагар	ТЭЗҮ-ийн шинжээчийн гэрээ	2020/04/30	2020/05/01	3,000,000₮
12	Иргэн Г.Бямбадоо	Тос халаагч тогооны гаднах тогоо хийх гэрээ	2020/05/01	2020/05/11	6,200,000₮
13	Иргэн Э.Мөнх-Од	Ажилчдын байр болох 40тн контэйнер засварлах гэрээ	2020/10/13	2020/11/13	5,510,000₮
14	Иргэн Р.Баянмөнх	Ачаа тээврийн гэрээ	2020/01/01	2020/12/31	Ачаа ачих бүр тн,км-ээр бодогдоно
Худалдах, худалдан авах гэрээ					
1	“Наранбулаг хан” ХХК	Мазут худалдах	2020/04/01	2021/04/01	387’000’000₮
2	“Монгол Битум Индустириал” ХХК	Мазут худалдах	2020/04/03	2021/04/03	170’000’000₮
3	“Дэвжих Эрдэнэ” ХХК	Мазут худалдах	2020/09/01	2020/12/31	125,923,000₮
4	“Хан Богд Вейст Менежмент Центр” ХХК /Оюу Толгой” ХХК/	Хамтын ажиллагааны гэрээ /Ажилласан масло нийлүүлэх/	2020/04/01	2021/04/01	Газар дээрээс нь очиж авах
5	“Богд Моторс” ХХК	Техникийн хаягдал тос авах	2020/05/05	2020/10/01	Газар дээрээс нь очиж авах
6	“ММК” ХХК	Техникийн хаягдал тос авах	2020/06/01	2021/03/31	Газар дээрээс нь очиж авах
7	“Хэт Моторс” ХХК	Техникийн хаягдал тос авах	2020/06/10	2021/03/31	Газар дээрээс нь очиж авах
8	“СэБоЦэ” ХХК	Техникийн хаягдал тос авах	2020/06/17	2021/03/31	Газар дээрээс нь очиж авах
9	“Аум алт” ХХК	Техникийн хаягдал тос авах	2020/08/14	2021/03/31	Газар дээрээс нь очиж авах
10	“АвтоХаб” ХХК	Техникийн хаягдал тос авах	2020/07/24	2021/03/31	Газар дээрээс нь очиж авах
11	Автоланд ХХК	Техникийн хаягдал тос авах			Газар дээрээс нь очиж авах


**Тайлант хугацаанд үйлдвэрлэлт борлуулалтаас гадна хийгдсэн ажлууд:**

1. “Аюултай хог хаягдал” цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд Байгаль Орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах үүднээс Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр гаргаж, өмнөх оны төлөвлөгөөний биелэлтийг тайлагнадаг.

2020.03.27-нд 2019 оны Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний Биелэлтийн тайлангаа хянуулж, 2020 оны Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө боловсруулж БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газраар баталгаажуулсан.



Зураг 1. 2019 он БОМ-ийн Биелэлтийн тайлан



*Зураг 2. 2020 он БОМ-ийн Төлөвлөгөө*


✓ Аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2. Компаний харуул хамгаалалтыг сайжруулах үүднээс харуулын байрыг компаний ажилчидаар бариулж ашиглалтанд оруулав.



*Зураг 3. Харуулын байр*

3. Үйлдвэрийн дотор болон хашаан доторхи , нийтийн эзэмшлийн талбайг хянах зориулалтаар өмнөх камеруудыг шинэчилж 30 хоног бичлэг хадгалах хүчин чадал бүхий 12 ширхэг камераар сольж суурилуулсан.



*Зураг 4. Камержуулалт*

✓ Авто машин тээврийн хэрэгсэл

4. Тайлант хугацаанд ажилчдын унаа машин (Prado, Starex) болон тосны цистернүүдэд (Kia Rhino) ээлжит урсгал засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, ЕС зөвшөөрөл, хот дотор явах түр зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн даатгал, татвар, улсын үзлэг, оношилгоонд бүрэн хамруулсан .



*Зураг 5. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ*

✓ Үйлдвэрийн тоног төхөөрөмж засвар үйлчилгээ

5. Техникийн хаягдал тос дахин боловсруулахад өдөрт 2тн усыг хөргөлтийн журмаар ашигладаг бөгөөд энэ усаа тусад нь саванд хийж хөргөн дахин ашигладаг байсныг үйлдвэр дотороо нэмж байрлуулан байнгын сэлгэн хөргөдөг болгож өөрчлөв.



*Зураг 6. Хөргөлтийн ус*

6. 2020.05.08 Үйлдвэрийн тос халаагч тогооны гадаргууд нь гэмтэл гарч шинээр солих шаардлагатай болсон тул иргэн Г.Бямбадоотой гэрээ хийж халаагч тогооны гадна их биеийг нь шинээр хийлгэж суурилуулан, үйлдвэрийн үйл ажиллагааг явуулахад бэлэн болгож хүлээн авсан болно.









11. Үйлдвэрийн гадна, дотно агаарын шинжилгээ

“НОГООН ТИТЭМ” ХХК  
Хан Уул дүүрэг, 3-р хороо,  
Сэн-Констракшн ХХК байр 222 тоот  
Утас: 70005432, 86096064

**НОГООН ТИТЭМ**  
АЖИРАА, ОРГИН ДЭГДЭЛЭЙН ЛАБОРАТОРИ

**Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын тайлан**

Ажлын дугаар: 200507  
Хэрэглэгчийн мэдээлэл: “Хай Би Ойл” ХК, Утас: 9996034  
Сорилтын мэдээлэл: СХД 20-р хороо Сонгоолон 110 тоот үйлдвэрийн гадна, дотор агаарын сорьц, цуглуулга  
Сорилтын тоо: 8

Сорилтын дугаар	Хэрэглэгч	Лаборатори	Сорилтын өртөг, л	Байршил
1. NO <sub>2</sub>	200607001N		10.83	Үйлдвэр дотор Үйлдвэрийн гадна
2. SO <sub>2</sub>	200607002S		10.57	
3. O <sub>3</sub>	200607003F		10.35	
4. VOC	200607004V121		10.09	
5. NO <sub>x</sub>	200607005N		10.25	
6. SO <sub>x</sub>	200607006S		10.10	
7. CO	200607007C			
8. H <sub>2</sub>	200607008H			

Сорилтын төрөл: Агаар  
Сорьц цуглуулах өгснөө: 2020-05-12  
Сорьц цуглуулсан: А.Бямбацогц, Лович  
Лабораторид хувиан авсан өгснөө: 2020-05-12  
Сорилт эхэлсэн өгснөө: 2020-05-12  
Сорилт дууссан өгснөө: 2020-05-15  
Хуудалын тоо: 4

Энэхүү сорилтын дүн нь хэрэглэгчээс ирүүлсэн тухайн сорьц, дотоо, хэмжээг биед авсан эх хувь хүчлэгчтэй.

Гүйцэтгэсэн: **НОГООН ТИТЭМ ХХК** А.Бямбацогц, Хилин  
Хансан: **НОГООН ТИТЭМ ХХК** П.Сайнаава, Чанарын хяналт

“НОГООН ТИТЭМ” ХХК  
Хан Уул дүүрэг, 3-р хороо,  
Сэн-Констракшн ХХК байр 222 тоот  
Утас: 70005432, 86096064

**НОГООН ТИТЭМ**  
АЖИРАА, ОРГИН ДЭГДЭЛЭЙН ЛАБОРАТОРИ

**Сорилтын дүнгийн хуудас**

Байршил-1: Үйлдвэр дотор  
Сорьц: Т: 20.2°C, Р: 1003 г/см<sup>3</sup>, Н: \_\_\_\_\_, С: \_\_\_\_\_  
Эхэлсэн цаг: 12:30, Дууссан цаг: 13:18

№	Тодорхойлох нэгдэл	Сорилтын өртөг, Стандарт	Илрүүлэх хязгар	Сорилтын дүн
1	Ажлын давхар ислэж, NO <sub>x</sub>	MNS ISO 6788:2005	3-3000	19.02
2	Хуурайлж, SO <sub>x</sub>	ISO 6787:1990	20-500000	19.83

**Органик биет нэгдэл**

№	Тодорхойлох нэгдэл	Сорилтын өртөг, Стандарт	Илрүүлэх хязгар	Хэмжээ
1	Формальдегид, CH <sub>2</sub> O	NCSN 3800	>0.5	<0.5

**Дэгдэжлийн өргөгч нэгдэл**

Сорьц VOC121

№	Тодорхойлох нэгдэл	Сорилтын өртөг, Стандарт	Илрэх хязгар	Илрүүлэх хязгар	Сорилтын дүн
1	Бензол	2.85	4-200	44	
2	Толуол	3.30	24-4510	31.28	
3	Этилбензол	3.29	45-8610	<45	
4	o-Ксилол	6.48	43-8610	<43	
5	p-Ксилол	7.64	44-10401	<44	

Тайлбар:  
- Бууц явцад тэмдэглэгдсэн сорилт хийгээгүй болно.  
- Бусад ба тэмдэглэгдсэн сорилтын өртөг, хэмжээг өөрөөр харахад болно.

Зураг 12. Үйлдвэрийн дотор агаар

“НОГООН ТИТЭМ” ХХК  
Хан Уул дүүрэг, 3-р хороо,  
Сэн-Констракшн ХХК байр 222 тоот  
Утас: 70005432, 86096064

**НОГООН ТИТЭМ**  
АЖИРАА, ОРГИН ДЭГДЭЛЭЙН ЛАБОРАТОРИ

**Сорилтын дүнгийн хуудас**

Байршил-2: Үйлдвэрийн гадна  
Сорьц: Т: 22°C, Р: 1013 г/см<sup>3</sup>, Н: \_\_\_\_\_, С: \_\_\_\_\_  
Эхэлсэн цаг: 13:20, Дууссан цаг: 14:00

№	Тодорхойлох нэгдэл	Сорилтын өртөг, Стандарт	Илрүүлэх хязгар	Сорилтын дүн
1	Ажлын давхар ислэж, NO <sub>2</sub>	MNS ISO 6788:2005	3-3000	51.72
2	Хуурайлж, SO <sub>x</sub>	ISO 6787:1990	20-500000	37.80

“НОГООН ТИТЭМ” ХХК  
Хан Уул дүүрэг, 3-р хороо,  
Сэн-Констракшн ХХК байр 222 тоот  
Утас: 70005432, 86096064

**НОГООН ТИТЭМ**  
АЖИРАА, ОРГИН ДЭГДЭЛЭЙН ЛАБОРАТОРИ

**Чанарын хяналт**

№	Наадгийн нэр	Нос	Шинэр	Сорилт урсгалын агуулга	Сорилтын утга
1	Ажлын давхар ислэж	миллсек	QC 200501N	0.680	0.620
2	Хуурайлж	мл	QC 200501P	17.766	17.362
3	Формальдегид	мл	QC 200501F	0.684	0.630

**Дэгдэжлийн өргөгч, нэгдэлийн чанарын хяналт**

№	Наадгийн нэр	Шинэр	Сорилт урсгалын агуулга	QC 200501
1	Бензол/Benzene	200 ± 3	мл/мл	200.38
2	Толуол/Toluene	180 ± 3	мл/мл	180.44
3	Этилбензол/Ethylbenzene	201 ± 4	мл/мл	200.68
4	o-Ксилол/o-Xylene	400 ± 8	мл/мл	418.73
5	p-Ксилол/p-Xylene	200 ± 4	мл/мл	192.87

**Монгол Улсын Стандарт**

№	Наадгийн нэр	MNS 4985:2016 Хөдөлмөрийн ажил үйлдвэр, ажил үйлдвэр, лаборатори-зүүн үйлдвэр, Ажлын байрны өргөгч, зүүн үйлдвэр, шалгалтын ЗДХ*	MNS 5885:2008 Агаарт байр болгох үйлдвэр, болон үйлдвэр хэмээн хэлжээ. Төлөөллийн өргөгчийн хяналтын стандарт. MNS 4985:2016 Ажлын байр, Төлөөллийн өргөгчийн хяналтын стандарт.
1	Ажлын давхар ислэж	2 000 мг/м <sup>3</sup> [8c]	300 мг/м <sup>3</sup> [30min] 70 мг/м <sup>3</sup> [24h] 40 мг/м <sup>3</sup> [1year]
2	Хуурайлж	2 000 мг/м <sup>3</sup> [8c]	430 мг/м <sup>3</sup> [30min] 70 мг/м <sup>3</sup> [24h] 70 мг/м <sup>3</sup> [1year]
3	Бензол	1.8 мг/м <sup>3</sup> [8c]	0.44 мг/м <sup>3</sup> [24h] 0.001 мг/м <sup>3</sup> [1year]
4	Толуол	90 мг/м <sup>3</sup> [8c]	18 мг/м <sup>3</sup> [30min] 5 мг/м <sup>3</sup> [24h]
5	Этилбензол	50 мг/м <sup>3</sup> [8c]	
6	o-Ксилол	90 мг/м <sup>3</sup> [8c]	3 мг/м <sup>3</sup> [30min] 3.3 мг/м <sup>3</sup> [24h] 0.75 мг/м <sup>3</sup> [24h]

\*ЗДХ-Шийтгэсэн гадна хэргийн хяналт.

Зураг 13. Үйлдвэрийн гадна агаар, чанарын хяналт

12. Үйлдвэрийн гадна тоосны шинжилгээ



Зураг 14. Тоосны шинжилгээ

13. Үйлдвэрийн хаягдал усны шинжилгээ



✓ Байгаль Орчин, Хөрс хамгаалалт

14. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газраас “Аюултай хог хаягдал”-ыг дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд 56 асуулт бүхий хяналтын хуудсаар шалгалт хийж,

эрсдэлийн үнэлгээ тогтооход 2019 онд бидний хийж бүтээсэн багагүй ажлын үр дүнд 15% буюу бага эрсдэлтэй гэсэн үнэлгээ авлаа. НМХГ-ын тогтоосон үнэлгээний дагуу хийх ажилд Био 00-г хийж ашиглахыг зөвлөсөний дагуу Био 00, явган зам хийж ашиглалтанд орууллаа.



Зураг 15. Био 00, явган замын ажил

15. 2020 оны БОМТ-ний дагуу үйлдвэрийн хашаан дотор хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн дагуу мод тарьж, зүлэгжүүлэх, ногоон байгууламжтай болгож мөн зам талбайг хатуу хучилттай болгож байна.



Зураг 16. Мод тарилт


16. Агаарт үүсэх тоосжилтоос сэргийлэх мөн хөрсийг хамгаалах чиглэлийн дагуу хашааны доторхи талбайн урд хэсэг, ажилчдын байрны урд талбайг хатуу хучилттай болгож бетондсон. Поошигтой хаягдал тос буулгах хэсгийг бетондож, хөрсний бохирдсон хэсгийн хорыг саармагжуулах ажил хийгдсэн.



Зураг 17. Бетоны ажил

✓ Тусгай зөвшөөрөл болон бусад үйл ажиллагааны сунгалт

17. Техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрийн галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан тул үйлдвэрийн галын аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагтай зүйлүүдийг нэмж хийн дүгнэлтийн хугацааг 2 жилээр сунгалт хийлгэв.



Зураг 18. Галын дүгнэлт

18. Тус компани нь БОАЖЯамнаас “Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах” үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019.07.26-нд 1 жилийн хугацаагаар авч амжилттай ажиллаж байгаа бөгөөд Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах сунгалтын бүрдүүлэх материалуудыг бэлэн болгож БОАЖЯаманд хүргүүлэн хурлаар орж 5 жилийн хугацаагаар сунгалаа.



Зураг 19. Тусгай зөвшөөрлийн сунгалтын хурлын үйл явц

19. Техникийн ашигласан тос дахин боловсруулах” үйлдвэрийн Техник Эдийн Засгийн Үндэслэлийг боловсруулан УУХҮЯ Ашигт Малтмал, Газрын Тосны Газар Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн дүгнэлт гаргуулж батлуулсан.УУХҮЯ-аас олгодог “Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл” эрхлэх тусгай зөвшөөрлийг журмын дагуу зохих материалуудыг бүрдүүлэн өгсөний үр дүнд авахад бэлэн болсон.



Зураг 20. Техник эдийн засгийн үндэслэлийн цахим хурал

✓ ХАБЭА-н талаар

20. Үйлдвэрийн нийт ажилчдад байгаль орчны талаархи боловсролыг дээшлүүлэх болон ХАБЭА-н тухай хуулийн дагуу хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар ХАБЭА-н мэргэжилийн хүнээр сургалт явуулж ажиллаа.



Зураг 21. ХАБ-ын сургалт


21. Аюултай хог хаягдлын менежмент мэргэжилийн сургалт  
“Аюултай хог хаягдал” болох техникийн ашигласан тосыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагааг явуулахад юуг анхаарах, ямар журам баримтлах, тухайн ажлын байранд ажилладаг ажилтан нь сургалтанд хамрагдсан байх зэргийг анхаарч нийт ажилчидаа Монголын химич, химийн инженер технологичдын холбооноос явуулдаг Химийн бодис болон аюултай хог хаягдалын талаарх сургалтанд хамруулж сертификаттай болгосон.



Зураг 22. Аюултай хог хаягдлын сургалт

22. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг

Манай компани нь УБ Сонгдо эмнэлэгтэй эрүүл мэндийн үзлэг болон багц шинжилгээ хийлгэх гэрээ байгуулж нийт ажилчдаа 2020 оны 11 дүгээр сарын 10-нд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрууллаа.



Зураг 23. Багцын шинжилгээ

23. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

Техникийн ашигласан тос дахин боловсруулах үйлдвэрийн байранд Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж, ажлын байранд нийт тоос, шуугиан, угаарын хий, хүхрийн давхар исэл, азотын давхар исэл, дэгдэмхий органик нэгдэл, агаарын температур, харьцангуй чийглэг, гэрэлтүүлэг гэсэн MNS 6656:2017, MNS 6767:2019, MNS 6766:2019, MNS 5387:2000, MNS 6767:2019, MNS 4991: 2000 стандартын шаардлагын дагуу хэмжиж үнэлгээ хийлгэв. MNS 5080:2001 стандартын ангиллын дагуу үнэлгээнд хамрагдсан ажлын байр хэвийн нөхцөлтэй байна гэж тодорхойлогдов.



Зураг 24. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний ажлын явц

✓ Олон нийтэд ажлаа тайлагнах, хэлэцүүлэх

24. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас найм дахь жилээ зохион байгуулсан “Ногоон технологи 2020” өдөрлөгт амжилттай оролцож байгаль орчинд хаягдаж болзошгүй Техникийн ашигласан тосыг дахин боловсруулдаг үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж, боловсруулан гаргаж байгаа M100 маркын мазутыг таницуулж оролцлоо. Манай компанийг нефтийн гаралтай хаягдал тосыг дахин боловсруулж, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологийг нэвтрүүлснийг үнэлж “Ногоон гэрчилгээ”-г олголоо. Мөн БОАЖЯ-ны сайд Д.Сарангэрэлд дахин боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, аюултай хог хаягдал болох ажилласан маслыг цуглуулах, боловсруулан гараж буй бэлэн бүтээгдэхүүний борлуулалтын талаар таницуулж санал бодлоо хуваалцлаа



Зураг 25. Ногоон гэрчилгээ олголт



Зураг 26. Ногоон технологи 2020 үзэсгэлэн  
БОАЖЯ-ны сайд Д.Сарангэрэлтэй хийсэн ярилцлага



25. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдлын менежментийн Удирдлага, зохицуулалтын хэлтэсээс төлөөлөгчид ирж манай ажилтай танилцаж, хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудтай хамтарч ажиллахаар олон ажлыг хэрэгжүүлж байгаа талаар ярилцаж санал бодлоо хуваалцлаа.

26. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газраас “Аюултай хог хаягдал”-ыг дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд 56 асуулт бүхий хяналтын хуудсаар шалгалт хийж, эрсдэлийн үнэлгээ тогтооход 2019 онд бидний хийж бүтээсэн багагүй ажлын үр дүнд 15% буюу бага эрсдэлтэй гэсэн үнэлгээ авлаа. НМХГ-ын тогтоосон үнэлгээний дагуу хийх ажилд Био 00 хийж хэрэглэхийг зөвлөсний дагуу бид Био -00 хийж гүйцэтгэсэн.

27. УУХҮЯамнаас ирсэн төлөөлөгчдөд Байгаль орчинд хаягдаж болзошгүй Аюултай хог хаягдлыг байгальд ээлтэйгээр дахин боловсруулж, эдийн засгийн эргэлтэнд оруулж байгаа төслийн ажлаа танилцуулж тайлагналаа.

**2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:**

Хай Би Ойл ХК-н 2020 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд: /төг-өөр/

1. 2020 оны ний борлуулалтын орлого	416,357,636
2. Бүтээгдэхүүний өртөг	376,104,299
3. Ашиг	<u>140,253,337</u>
Ерөнхий удирдлагын зардал:	/БӨ-т ороогүй/ <u>172,986,947</u>

Үүнээс:

• Цалин /захиргаа/	72,739,881
• НДШ төлөлт	3,895,413
• Томилолт	432,780
• Бичиг хэрэг	542,968
• Шатахууны зардал	1,165,442
• Элэгдэл /захиргаа/	13,470,020
• Мэргэжлийн үйлчилгээ /хууль, зөвшөөрөл г.м/	19,909,090
• Шуудан хобоо, интернет	1,472,727
• Бусад /Засвар, бои 00, манаач, ажилчдын байр г.м/	57,638,795
• Сургалт	900,000 г.м

Бусад зарлага:

• Өмнөх оны дансны өглөгийг төлсөн	<u>216,116,870</u>
------------------------------------	--------------------

Хай Би Ойл ХК-ийн  
2020 оны санхүүгийн тайлангийн  
бодит байдлын тухай мэдэгдэл

2021 оны 3 сарын 29 өдөр

Захирал Ш.Амар-Отгон, ерөнхий нягтлан бодогч Б.Бадамханд бид манай аж ахуйн нэгжийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, ер төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Захирал

*Ш. Амар-Отгон* Ш.Амар-Отгон

Ерөнхий нягтлан бодогч



Б.Бадамханд

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ХАЙ БИ ОЙЛ ХК  
( Аж ахуйн нэгжийн нэр )

2020 оны 12 сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Мерийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	252,039,809.91	35,691,706.40
1.1.2	Дансны авлага	1,464,897,503.00	161,640,418.01
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	3,491,190.86	27,286,881.49
1.1.4	Бусад авлага	492,944,178.30	2,285,567,519.32
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	134,310,757.74	126,222,517.22
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	20,610,324.63	4,857,066.21
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10		0.00	0.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,368,293,764.44</b>	<b>2,641,266,108.65</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,042,595,730.08	1,222,667,953.85
1.2.2	Биет бус хөрөнгө	0.00	869,916,700.00
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,691,233,612.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.9		0.00	0.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,733,829,342.08</b>	<b>2,092,584,653.85</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,102,123,106.52</b>	<b>4,733,850,762.50</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	228,267,741.85	58,842,580.01
2.1.1.2	Цалингийн өглөг	129,136,875.43	0.00
2.1.1.3	Татварын өр	7,043,098.55	228,890.59
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.01
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	117,293,641.00	77,473,226.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12		0.00	0.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>481,761,356.83</b>	<b>136,544,696.61</b>

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	78,003,580.38	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>78,003,580.38</b>	<b>0.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>559,764,937.21</b>	<b>136,544,696.61</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	0.00	0.00
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- хувьцаат	5,211,895,400.00	5,211,895,400.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	-54,281,480.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	4,592,503,138.14	4,592,503,138.14
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	1,108,461,115.93
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-5,262,040,368.83	-6,261,272,108.18
2.3.10		0.00	0.00
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,542,358,169.31</b>	<b>4,597,306,065.89</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,102,123,106.52</b>	<b>4,733,850,762.50</b>

Захирал

Ерөнхий нягтлан бодогч



М. Амар-Отгон

Б. Бадамханд

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ХАЙ БИ ОЙЛ ХК  
( Аж ахуйн нэгжийн нэр )

2020 оны 12 сарын 31 өдөр

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>760,366,545.50</b>	<b>416,357,636.38</b>
2	Борлуулалтын өртөг	415,669,385.81	276,104,299.00
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>344,697,159.69</b>	<b>140,253,337.38</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	2,107,353.32	427,291.66
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	381,020.73	504,751,759.16
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	268,956,468.06	173,986,947.07
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	31,678.77
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	65,542,628.04	4,147.25
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(706,403.18)	(34,973.72)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	(1,678,995,229.89)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>143,065,290.54</b>	<b>(1,207,612,294.00)</b>
19	Орлогын татварын зардал	14,598,337.47	-
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>128,466,953.07</b>	<b>(1,207,612,294.00)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>128,466,953.07</b>	<b>(1,207,612,294.00)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>128,466,953.07</b>	<b>(1,207,612,294.00)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

Захирал



Ш.Амар-Отгон

Ерөнхий нягтлан бодогч

Б.Бадамханд

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ХАЙ БИ ОЙЛ ХК  
(Аж ахуйн нэгжийн иэр)

2020 оны 12 сарын 31 өдөр  
/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халааны хувицаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,211,895,400.00	-	4,592,503,138.14	-	-	-	(5,390,507,321.90)	4,413,891,216.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		19.2 Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз						-
3	Залруулсан үлдэгдэл	5,211,895,400.00	-	4,592,503,138.14	-	-	-	(5,390,507,321.90)	4,413,891,216.24
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							128,466,953.07	128,466,953.07
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,211,895,400.00	-	4,592,503,138.14	-	-	-	(5,262,040,368.83)	4,542,358,169.31
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							208,380,554.66	208,380,554.66
11	Залруулсан үлдэгдэл	5,211,895,400.00	-	4,592,503,138.14	-	-	-	(5,053,660,814.17)	4,750,738,723.97
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(1,207,612,294.00)	(1,207,612,294.00)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				1,108,461,115.93				1,108,461,115.93
14	Өмчид гарсан өөрчлөлт		(54,281,480.00)						(54,281,480.00)
15	Зарласан ногдол ашиг								-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
17	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,211,895,400.00	(54,281,480.00)	4,592,503,138.14	1,108,461,115.93	-	-	(6,261,272,108.18)	4,597,306,065.89

Захирал



Н.Б. Өвөр, Б.Бадамжар

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ХАЙ БИ ОЙЛ ХК  
( Аж ахуйн нэгжийн нэр )

2020 оны 12 сарын 31 өдөр  
/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>913,261,807.00</b>	<b>462,108,054.03</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	913,261,807.00	459,686,204.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	-	2,421,850.03
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>715,265,114.82</b>	<b>645,833,291.27</b>
	Ажиллагчдад төлсөн	132,930,747.92	143,642,850.85
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	38,860,576.38	14,237,478.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	294,142,937.37	174,829,077.03
	Ашиглалтын зардалд төлсөн	22,278,000.00	17,346,700.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,273,717.56	16,207,943.65
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	78,546,047.69	56,694,648.64
	Даатгалын төлбөрт төлсөн	289,332.00	241,110.00
	Бусад мөнгөн зарлага	122,943,755.90	222,633,482.18
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>197,996,692.18</b>	<b>(183,725,237.24)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>2,089,353.32</b>	<b>373,021.36</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	2,089,353.32	373,021.36
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
		-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	<b>33,000,000.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	33,000,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
		-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>2,089,353.32</b>	<b>(32,626,978.64)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>8,344.79</b>	<b>4,112.37</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>200,094,390.29</b>	<b>(216,348,103.51)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>51,945,419.62</b>	<b>252,039,809.91</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>252,039,809.91</b>	<b>35,691,706.40</b>

Захирал

*Ш.Амар-Отгон*

Ш.Амар-Отгон

Ерөнхий нягтлан бодогч

*Б.Бадамханд*

Б.Бадамханд



**5. 2020.04.27 “Хай Би Ойл” ХК-ийн ХЭХ-ын хурлын талаар:**

1) 2020 оны 04 сарын 27-ны өдрийн Даваа гаригийн 10:00 цагт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Pearl tower барилга, В корпус, 9 давхар 2 тоотод зарлан хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- a) Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- b) Компанийн 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- c) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн сонгох;
- d) Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

Дээрх хуралдааны тогтоол шийдвэрүүдийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, түүний вэб хуудсанд тухай бүр өгч хууль дүрэм, журмын дагуу байршуулан ажилласан.

**Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:**

Компани нь нийт 52 118 954 ширхэг хувьцаатай ба 379 хувьцаа эзэмшигчидтэй байна. Үүнээс нийт хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны	
		Тоо ширхэг	Хувь
1	“БиДиСЕК” ХК	8 252 197	15.84%
2	“Кибер Циркл” ХХК	16 609 841	31.87%
3	“Нью альфа” ХХК	17 327 908	33.25%
4	“Монгол алтан минт” ХХК	4 167 934	8.00%
<b>Дүн</b>			<b>88.96%</b>

/ ҮЦГХТ-өөс 2020.04.07-ний өдрөөр тасалбар болгон авсан мэдээ. /

**Удирдлагын талаархи мэдээлэл:**

2020.04.27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Пүрэвбаатар, Б.Лхагвадорж, А.Батбаяр, С.Одгэрэл, Р.Оюунбат, Ж.Эрдэмбилэг нар, хараат бус гишүүдээр А.Харцага, Т.Тамир, Ц.Батбаяр нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Пүрэвбаатар, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-отгон, ТУЗ-ийн нарийн бичгээр Н.Батнайрамдал нар сонгогдож ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

**ТУЗ-ийн хурлын талаар:**

Тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 6 удаа санал асуулгаар хуралдсан байна.

Үүнд:

1. 2020 оны 01 сарын 07-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж
  - a. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Батбаатарыг чөлөөлөх
  - b. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилох тухай асуудлуудыг хэлэлцээд ТУЗ-ын дарга Б.Батбаатарыг чөлөөлж, Ц.Батбаярыг ТУЗ-ын даргаар томилсон.



ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, түр гишүүнээр Б.Батхуягийг томилох

2. 2020 оны 02 сарын 18-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж
  - а. 2019 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай
  - б. Аудитын компанитай гэрээ байгуулах тухай асуудлыг хэлэлцэж “Юнистар аудит” ХХК-аар “Хай Би Ойл” ХК-ийн жилийн эцсийн санхүүгийн тайлан балансад аудит хийлгэх, 2019 оны үйл ажиллагаанаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлахгүй байх тус тус шийдвэр гаргасан.
3. 2020 оны 03 сарын 18-ны өдөр саналын хуудсаар “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг 2020 оны 04 сарын 27-ны өдөр хуралдуулхаар шийдвэрлэсэн.
4. 2020 оны 05 сарын 15-ний өдөр саналын хуудсаар хуралдаж, 2020 оны 04 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралаар томилогдсон ТУЗ-ын гишүүдээс ТУЗ-ын дарга, ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнүүдийг болон ТУЗ-нарийн бичгийн даргыг тус тус томилж тогтоол гаргасан.
5. 2020 оны 06 сарын 03-ний өдөр саналын хуудсаар ТУЗ-ын гишүүдэд санал хүргүүлж, “Хай Би Ойл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ш.Амар-отгонг улируулан томилох шийдвэр гаргасан.
6. 2020 оны 10 сарын 19-ны “Хай Би Ойл” ХК-ийн үйлдвэрлэлийн түүхий эд материал зөөж, тээвэрлэхэд нэн шаардлагатай байгаа өргөгчтэй, ердийн тэвштэй автомашиныг худалдан авах тухай зөвшөөрөлийг олгож шийдвэрлэсэн болно.